



**МОНГОЛ НААДАМ ЦОГЦОЛБОР ОНӨТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2016 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/11

Улаанбаатар хот

**Байгууллагын эд хөрөнгийг түрээслүүлэх
журам батлах тухай**

Монгол Улсын Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 28 дугаар зүйлийн 28.2, Засгийн газрын 134 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам”, Байгууллагын дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.10.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Байгууллагын эд хөрөнгийг түрээслүүлэх журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, түрээсийн төлбөрийн жишиг үнийг “Байгууллагын эд хөрөнгүүдийн зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн гаргасан жишиг үнэ”-ийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиалагч менежер /М.Жаргалсайхан/-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЦОГТБААТАР

0000000043


“Монгол Наадам Цогцолбор” Орон Нутгийн Өмчит Төсөвт
Үйлдвэрийн Газрын даргын 2016 оны 03 дугаар сарын 11-
ны өдрийн 11 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

БАЙГУУЛЛАГЫН ӨМЧИЙН ЭД ХӨРӨНГИЙГ ТҮРЭЭСЛҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын төрийн өөрийн өмчийн “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ-ын эд хөрөнгө (цаашид “байгууллагын эд хөрөнгө” гэнэ)-ийг иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу түрээслүүлэхэд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

1.2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т зааснаар байгууллагын бүх төрлийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлж болно.

1.3. Байгууллагын эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээсээр эзэмшүүлэх зорилго нь төрийн өмчийн ашиглалтыг сайжруулж, үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгийг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ.

1.4. Байгууллагын эд хөрөнгийг түрээсээр эзэмшигч, ашиглагч нь эд хөрөнгийн баталгаа, төлбөрийн чадвартай Монгол Улсын иргэн, хуулийн этгээд (цаашид “түрээслэгч” гэнэ) байна.

1.5. Байгууллагын эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэгч нь “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ (цаашид “түрээслүүлэгч” гэнэ) байна.

1.6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсэгт заасны дагуу түрээслүүлэгч нь нэг зориулалттай, нэгдмэл байдалтай ашиглагдах цогцолбор төрийн өөрийн өмчийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх эд хөрөнгийг түрээслүүлэхдээ авна.

1.7. Түрээслүүлэгч болон түрээслэгчийн хоорондын харилцааг хууль тогтоомж, энэ журамд заасны дагуу байгуулсан түрээсийн гэрээгээр зохицуулна.

1.8. Төрийн өөрийн өмчийн тухайн эд хөрөнгийг хоёр буюу түүнээс дээш этгээд түрээслэх бол түрээсийн гэрээний нөхцөлийг түрээслэгч, түрээслүүлэгч харилцан тохиролцоно. Харин төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг зөвхөн нэг этгээдэд түрээслүүлэх бол түрээслэгчийг сонгон шалгаруулна.

1.9. Байгууллагын эд хөрөнгийг түрээслэгч нь түрээсээр эзэмшиж буй төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг дамжуулан түрээслүүлэх, хамтран түрээслэх, эрх залгамжлан түрээслэх бол “Монгол Наадам Цогцолбор” Орон Нутгийн Өмчит Төсөвт Үйлдвэрийн Газрын зөвшөөрөл авна.

1.10. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар, түрээслэгчийг сонгон шалгаруулах журмыг Орон Нутгийн Өмчит Төсөвт Үйлдвэрийн Газрын дарга батална.

1.11. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн жишиг үнийг зах зээлийн үнийн судалгаанд үндэслэн “Монгол Наадам Цогцолбор” ОНӨТҮГ тогтооно.

Хоёр. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулах

2.1. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн гэрээг Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журамд нийцүүлэн бичгээр байгуулна.

2.2. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн гэрээний хугацааг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол түрээслэж буй эд хөрөнгийн шинж байдал, зориулалт, онцлогийг харгалзан талууд харилцан тохиролцож тогтооно.

2.3. Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийг түрээслүүлэхдээ түрээсийн төлбөрийн хэмжээг энэ журмын 2 дугаар хавсралтад заасан жишиг үнийг баримтлан, зах зээлийн тухайн үеийн үнэ болон бусад холбогдох үзүүлэлтүүдийг харгалзан тогтоож, гэрээнд тусгана.

2.4. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн төлбөрийг "Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ төвлөрүүлж улсын төвлөрсөн төсөвт оруулна.

2.5. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн гэрээний биелэлтэд "Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ хяналт тавина.

2.6. Түрээслэгч нь төрийн өөрийн өмчийн байгууллагын эд хөрөнгийг түрээсээр эзэмших хугацаандаа түүний бүрэн бүтэн байдал, урсгал засварыг хариуцах бөгөөд "Монгол Наадам Цогцолбор" ОНӨТҮГ-ын зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, хөрөнгө оруулалт хийхийг хориглоно.

Гурав. Байгууллагын эд хөрөнгийн түрээсийн гэрээг цуцлах

3.1. Түрээслэгч төрийн өөрийн өмчийн байгууллагын эд хөрөнгийн түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн буюу төлбөрийн чадваргүй болсон, эсхүл гэрээнд тусгайлан заасан тохиолдолд түрээслүүлэгч дангаар гэрээг цуцалж учирсан хохирлыг төлүүлнэ.

Дөрөв. Байгууллагын эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэх

4.1. Байгууллагын эд хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэхтэй холбогдсон маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

Төсөл

“Монгол Наадам Цогцолбор” Орон Нутгийн Өмчит Төсөвт
 Үйлдвэрийн Газрын даргын 2016 оны 03 дугаар сарын
 ны өдрийн дугаар тушаалын 2 дугаар хавсралт

БАЙГУУЛЛАГЫН ЭД ХӨРӨНГҮҮДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНИЙН
 СУДАЛГААНД ҮНДЭСЛЭН ГАРГАСАН ЖИШИГ ҮНЭ

Д/д	Үйлчилгээний төрөл	Хэмжих нэгж	Түрээслэх хугацаа	Үнэ тариф /төгрөгөөр/
1	Амралтын гэрийн түрээсийн үнэ /Зуны улиралд/	ширхэг	1 хоног	50 000
2	Амралтын гэрийн түрээсийн үнэ /Өвлийн улиралд/	ширхэг	1 хоног	60 000
3	10 ханатай үйлчилгээний гэрийн түрээсийн үнэ /караоке-той/	ширхэг	1 хоног	180 000
4	Снукер биллъярд тоглуулах түрээсийн үнэ	ширхэг	1 цаг	8 000
5	Ширээний теннис тоглуулах түрээсийн үнэ	ширхэг	1 цаг	3 000
6	Унадаг дугуйн түрээсийн үнэ	ширхэг	1 цаг	5 000
7	Унадаг дугуйн түрээсийн үнэ	ширхэг	1 хоног	10 000
8	Гудамжны сандлын түрээсийн үнэ	ширхэг	1 ширхэг	10 000
9	Гудамжны хогийн сав түрээсийн үнэ	ширхэг	1 ширхэг	3 000
10	Агуулах түрээслэх үнэ	м2	1 хоног	3000- 3500
11	Монгол асар майхан түрээсийн үнэ 4*6м, 4*9м-тэй	ширхэг	1 хоног	60 000
12	Асар майхан түрээсийн үнэ 4*4м-тэй	ширхэг	1 хоног	90 000
13	Тайз, карказ, тавцан түрээсийн үнэ	иж бүрэн 10*8м2	1 удаагийн арга хэмжээ	2 000 000
14	Лед дэлгэцийн түрээсийн үнэ	иж бүрэн 4*5м2	1 удаагийн арга хэмжээ	500 000
15	Тайзны гэрлийн түрээсийн үнэ	ширхэг	1 удаагийн арга хэмжээ	40 000
16	Хөгжмийн түрээсийн үнэ	иж бүрэн	1 удаагийн арга хэмжээ	2 500 000
17	Гадаа зориулалтын тугны суурины түрээсийн үнэ	ширхэг	1 хоног	20 000
18	Ёслолын тусгаарлах шонгийн түрээсийн үнэ /ширхэгээр/	ширхэг	1 хоног	10 000
19	Эко автобус түрээсийн үнэ /100км явна/	ширхэг	1 удаагийн арга хэмжээ	60 000
20	Контейнэрэн нойлын үйлчилгээний түрээсийн үнэ	Ширхэг	1 удаагийн арга хэмжээ	40 000- 80 000

БОЛОВСРУУЛСАН
 СОЁЛ, УРЛАГ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Б.СОЛОНГО